

**БАТЛАВ:**

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГА Г.ЧИНЗОРИГ**



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын Газар**

**“РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ ХЯНАЛТ МОНИТОРИНГ  
ХИЙХ” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

**ТЕНДЕРИЙН ДУГААР: ХХЗХ/202401038  
БАГЦЫН ДУГААР: БАГЦ 1 - УЛААНБААТАР ХОТЫН РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ ТҮҮВРЭЭР ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ**

2024 он



## АГУУЛГА

1. Үндэслэл
2. Зорилго
3. Хяналт, мониторингийн хамрах хүрээ
4. Хяналт, мониторинг хийх үзүүлэлт
5. Хяналт, мониторинг хийхэд баримтлах зарчим
6. Тайлан
7. Ажлын даалгаврын шалгуур шаардлага
8. Хэрэгжүүлэх арга зүй ба ажлын хуваарь
9. Тайлан ирүүлэх удирдамж
- 10.Хавсралт 1

## **1. ҮНДЭСЛЭЛ**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2011 оноос хойш хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хөгжлийг дэмжих, Монгол улсын холбогдох хууль тогтоомж, өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд хүүхэд, сонсогч олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөр, зар сурталчилгаанд тус хорооноос батлан гаргасан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д заасан хэмжигдэхүйц тодорхой үзүүлэлтүүдээр хяналт, мониторинг хийж ирсэн болно.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдаж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан эрх, чиг үүргийн хүрээнд Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам батлан гаргаж, хэрэгжилтэнд хяналт, мониторинг хийх, хяналт мониторингийн дүнг олон нийтэд мэдээлэн ажиллах чиг үүрэгтэй.

Тус хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8-д заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан шаардлага болон хуульд заасан дээрх журам, нөхцөл шаардлагуудын хэрэгжилтэнд хяналт тавих дээрх чиг үүргийн хүрээнд 2024 онд радиогийн хөтөлбөрт түүврийн аргаар байнгын хяналт, мониторинг хийж хяналт, мониторингийн дүн, мэдээнд үндэслэн холбогдох тайлан мэдээг гаргах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах юм.

## **2. ЗОРИЛГО**

Энэхүү ажлын даалгаврын зорилго нь ХХЗХ-оос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, 30.1.8-д заасан чиг үүргээ хэрэгжүүлж, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан шаардлага болон тус хуульд заасан Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 35 радиогийн үйлчилгээ эрхлэгчдээс (МҮОНР-4, арилжааны 31 радио)-32 радиогийн хөтөлбөрт сар бүр түүврээр хяналт, мониторинг хийхэд (цаашид “хяналт, мониторинг хийх” гэх) оршино.

Радиогийн хөтөлбөрт түүврийн аргаар хяналт, мониторинг хийхдээ дээрх нөхцөл шаардлагуудын үзүүлэлт нэг бүрийг хангаж ажилласан эсэх дүнг сар бүр нэгтгэн гаргах, нээлттэй байршуулах, сар бүр, улирал, жилийн нэгдсэн дүнгээр холбогдох харьцуулалтыг хийх, судалгаа гаргах, нөхцөл шаардлага хангаагүй

үзүүлэлтийг ил тод байршуулах, зөрчлийг арилгуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч ажиллах юм.

Радиоогийн бэлтгэн нэвтрүүлж байгаа хөтөлбөрт түүврийн аргаар хийгдэж байгаа хяналт, мониторингийн дүн мэдээнд үндэслэн шаардлагатай судалгаа, мэдээллийг мөн улирал, жилээр гаргаж ажиллах бөгөөд үүний үр дүнд радиоогийн зах зээлийн мэдээлэл, зар сурталчилгааны зах зээлийн судалгаа, статистик тоон мэдээлэл бүрдэх, өргөн нэвтрүүлгийн талаарх бодлого, зохицуулалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, боловсронгуй болгох улмаар цаашдын чиг хандлагыг тодорхойлох судалгааны суурь мэдээлэл бүхий бааз бий болгох ач холбогдолтой юм.

Түүнчлэн илэрсэн зөрчил дутагдал, нөхцөл шаардлагад заасан чиглэлээр гомдол маргаан үүссэн тохиолдолд ашиглах эфирийн бичлэг, тайлан, бүртгэлийн архив, сан үүсэх боломж бүрдэх болно.

### **3. МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ**

- 3.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй радиоогийн үйлчилгээ эрхлэгчдээс /цаашид радио гэх/ захиалагчийн гаргасан графикийн дагуу сар бүр 10 радиоогийн хөтөлбөрт 2024 оны 03 дугаар 01-ний өдрөөс 2025 оны 02 дугаар 28-ны өдрийг дуусталх буюу нийт 12 сарын хугацаанд хяналт мониторинг хийнэ.
- 3.2 Гэрээт ажлын хугацаанд аливаа гомдол, маргаан, хууль тогтоомжид заасан үзүүлэлтээр тодруулга мэдээлэл авахтай холбоотой радиоогийн хөтөлбөрийн бичлэг, холбогдох бүртгэлийн мэдээллийг тухай бүр, шуурхай гаргах боломжтой байна.
- 3.3 Хяналт, мониторингийг өглөөний 06.00 цагаас шөнийн 24:00 цаг хүртэлх эфирийн цагаар хийх ба шаардлагатай нөхцөлд хяналт, мониторингийн цагийг 1-2 цагаас илүүгүйгээр сунгаж болно.
- 3.4 Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээт ажлын хугацаанд өөрийн хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс тухайн маргаантай холбоотой:
  - Хяналтад хамрагдаж байгаа радиоогийн хөтөлбөрийн бичлэг авах, холбогдох мэдээллийг гаргуулж авах;
  - Тухайн сард хяналтад хамрагдаагүй радиоогийн тухайд Захиалагч талаас гүйцэтгэгч талд өгч, шаардлагатай протокол, мэдээллийг гаргуулж авах эрхтэй
- 3.5 Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын даалгаварт заасан хяналтын үзүүлэлтээр гарсан тайлан нь Захиалагчийн өмч болох тул шаардлагатай тохиолдолд хамтын ажиллагаатай холбогдох төрийн байгууллагуудад холбогдох тайлан, мэдээллийг хүргүүлж болно.

#### **4. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТ**

##### ***Хөтөлбөрт тавигдах үндсэн шаардлага – чиглэлээр***

- 4.1 Радиогийн хөтөлбөрийн үндсэн, дэлгэрэнгүй протокол гаргах. Үүнд: Радиогийн нэр, огноо, эфирт гарсан нэвтрүүлгийн нэр, нэвтрүүлэг тус бүрийн эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, төрөл, жанр гэх мэт мэдээллүүдийг агуулсан дэлгэрэнгүй хэлбэртэй байхаар гаргах;
- 4.2 Хөтөлбөрт эзлэх үндэсний бүтээл, нэвтрүүлгийн (7 хоногийн хөтөлбөрийн 50%-аас доошгүй байх) шаардлагыг хангасан эсэх;
- 4.3 Гадаад болон Монгол дууны нийт цаг, эзлэх нийт хувь хэмжээг 7 хоног бүрээр тодорхойлох, Монгол дууны хувь хэмжээ нь (7 хоногийн хөтөлбөрт эзлэх нийт дууны 25%-аас доошгүй байх) шаардлагыг хангасан эсэх;
- 4.4 Хөтөлбөрт эзлэх өөрийн бүтээлийн хувь хэмжээ нь (7 хоногийн хөтөлбөрийн 30%-аас доошгүй нь байх) шаардлагыг хангасан эсэх;
- 4.5 Хөтөлбөрт эзлэх хөтлөлттэй шууд нэвтрүүлгийн хувь хэмжээ нь (7 хоногийн хөтөлбөрийн 15%-аас багагүй байх) шаардлагыг хангасан эсэх; шууд хөтлөгчтэй болон хөтлөгчтэй нэвтрүүлгийг ялган харуулах;
- 4.6 Үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийн (тухайн мониторингийн хугацаанд) нийт цагийг тодорхойлох;
- 4.7 Хүүхдийн нэвтрүүлгийн нийт цаг, хүүхдийн нэвтрүүлгийг 21:00 цагаас хойш нэвтрүүлсэн эсэх, хүүхдэд зориулсан зар сурталчилгаанаас өөр зар сурталчилгаа явуулсан эсэх;
- 4.8 Насанд хүрэгчдэд зориулсан 18 наснаас дээш насныханд зориулсан нэвтрүүлгийг 06:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлсэн, давтан дамжуулж байгаа эсэх (өдөр бүрээр);
  - 4.8.1. Илт зохисгүй агуулга, үг хэллэг бүхий нэвтрүүлгийг бүртгэлжүүлэх, тайлан, мэдээнд тусгах;
- 4.9 Нэвтрүүлэгт тусгай дугаар ашигласан тохиолдолд үнэ тарифыг ил тод мэдээлэх шаардлагыг хангасан эсэх (ашиглаж буй тусгай дугаар, тусгай дугаарын үнэ тарифыг зарлаж буй эсэх);

##### ***Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгаанд тавигдах үндсэн шаардлага - чиглэлээр***

- 4.10 Нэвтрүүлж буй зар сурталчилгааны хугацааг тогтоох, үүнд: “1 цагт дамжуулах зар сурталчилгаа 18 минутаас илүүгүй байх” шаардлагыг хангасан байдал;
- 4.11 Зар сурталчилгааны 1 блокийн хугацаа нь (1 блокийн үргэлжлэх хугацаа 3 минутаас илүүгүй байна) шаардлагыг хангасан эсэх; зөрчлийн тоо /өдөр бүрээр/
- 4.12 Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлгийн хувь хэмжээ нь (1 өдрийн хөтөлбөрийн 10%-аас илүүгүй байх) шаардлагыг хангасан эсэх;

### **Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгаанд тавигдах бусад шаардлага – чиглэлээр**

- 4.13 Зар сурталчилгаанд эзлэх нийгмийн зар сурталчилгааны хугацааг тогтоох, зар сурталчилгааг төрлөөр нь ангилах;
- 4.14 Ивээн тэтгэлттэй нэвтрүүлэг, захиалгат нэвтрүүлэг, төлбөрт нэвтрүүлгийг мэдээлсэн эсэх;
- 4.15 Зар сурталчилгааг нийлүүлэгч, үйл ажиллагааны чиглэл /салбар/-ээр нь ангилан гаргах

### **Бусад шаардлага - чиглэлээр**

- 4.16 Хөтөлбөрт цаг үе, үйл явдлын мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн эзлэх хувь хэмжээг тодорхойлох; Мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг дундуур зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- 4.17 Мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох үзүүлэлтээр нэмэлт мэдээ, тайланг боловсруулалт хийн түргэн шуурхай гаргах боломжтой байх.

## **5. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ ЧИГЛЭЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

Хяналт, мониторинг хийх үзүүлэлтүүд нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”, “Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам” зэрэг хууль, холбогдох баримт бичгүүдэд үндэслэнэ. Хяналт, мониторинг хийхдээ дараах зарчмыг удирдлага болгон баримтална. Тухайлбал:

- 5.1 Үндэсний бүтээл, нэвтрүүлгийн хувь хэмжээг тооцохдоо:
  - ✓ “Үндэсний нэвтрүүлэг” гэдэгт Соёлын тухай хуулийн 3.1.8 дахь заалтад заасан Монгол улсад бүтээгдсэн бүх төрлийн бүтээлийг ойлгоно.
  - ✓ Нэвтрүүлгийн давталтыг оруулж тооцно.
  - ✓ Үндэсний бүтээл, нэвтрүүлэгт реклам, арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг, төлбөрт, захиалгат нэвтрүүлэг хамаарахгүй.
- 5.2 Өөрийн бүтээлийн хувь хэмжээг тооцохдоо:
  - ✓ “Өөрийн бүтээл” гэдэгт өөрийн редакцийн бодлогын хүрээнд бэлтгэж нэвтрүүлсэн бүтээлийг ойлгоно.
  - ✓ Өөрийн бүтээлд арилжааны зар сурталчилгаа (реклам), арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг,
- 5.3 Хөтлөлттэй шууд нэвтрүүлгийн эзлэх хувийг тооцохдоо:
  - ✓ Хөтлөгчтэй шууд нэвтрүүлгийг авч үзэхдээ тухайн нэвтрүүлэг эхэлсэн цагаас дуусах хүртэл бүрэн тооцогдоно. (тухайн нэвтрүүлэг дундуур дуу явуулсан байсан ч нийт цагаар авч үзэх)
  - ✓ Шууд нэвтрүүлэг болон хөтлөлттэй нэвтрүүлгийг ялгаж үзэх.
  - ✓ Нэвтрүүлгийн давталтыг оруулж тооцно.
- 5.4 Үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийн хувийг тооцохдоо:

- ✓ Танин мэдэхүйн нэвтрүүлэгт шинжлэх ухаан, түүх, соёл, зан заншил, хэл зохиол, урлаг, соёлын өвийг тайлбарлан таниулсан баримтат бүтээл, нэвтрүүлгийг ойлгоно.
  - ✓ Аливаа шашин, шашны урсгал, чиглэлийн талаарх нэвтрүүлэг, номлол, сургаалийг тусад нь бүртгэлжүүлэх.
- 5.5 18 + насныханд зориулсан нэвтрүүлгийг тооцохдоо:
- ✓ Насанд хүрэгчдэд зориулсан насны ангилалд тохирсон буюу 18 наснаас дээш насныханд зориулсан нэвтрүүлгийг 6:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлэхгүй, давтан дамжуулахгүй байна.
  - ✓ Зөвлөгөө, мэдээлэл өгч байгааг оруулж тооцохгүй.
  - ✓ Эргэлзээтэй мэдээлэл, зөрчил гэж тодорхойлсон тохиолдолд линк ирүүлж тодорхойлох
- 5.6 Зар сурталчилгааны хугацааг тооцохдоо:
- ✓ Радиогийн үйлчилгээ эрхлэгч нь зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг тогтсон үг хэллэг, богино ая, дуу ашиглан сонсогчдод ойлгомжтой байдлаар илэрхийлнэ.
  - ✓ Нийгмийн шинжтэй зар сурталчилгаа, өөрийн болон хөтөлбөрөө сурталчилсан сурталчилгааг зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцохгүй.
  - ✓ Үгэн зарыг Монгол хэлний хэм хэмжээ, зөв дуудах ёс, зүй тогтолд нийцүүлэн урьдчилан бэлтгэж, хөтөлбөрийн хуваарьт оруулан нэвтрүүлэх бөгөөд үгэн зарыг 1 цагт дамжуулах зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцно.
  - ✓ Ивээн тэтгэгчтэй нэвтрүүлгийн ивээн тэтгэгчийг, төлбөрт, захиалгат нэвтрүүлгийг тухайн нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд болон нэвтрүүлгийн явцад дурдаж, сонсогчдод ойлгомжтой байдлаар мэдээлнэ.
  - ✓ Хүүхдийн нэвтрүүлэг дундуур хүүхдэд зориулсан зар сурталчилгааг нэвтрүүлнэ.
  - ✓ Мэдээний дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй.

## 6. ТАЙЛАН

- 6.1 Хяналт, мониторинг хийгдсэн хугацааны эфирийн 06:00-24:00 цагийн /хөтөлбөрийн/ өдөр бүрийн дэлгэрэнгүй протокол, дэлгэрэнгүй протоколд тухайн нэвтрүүлэг эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, тайлбар зэрэг бүх л мэдээллийг агуулсан байна.
- 6.2 Ажлын даалгаврын 4-р зүйлд заасан хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр нэвтрүүлэг эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацааг цаг:мин:сек-ээр гаргах, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, нэмэлт тайлбарыг гаргах; */тайлангийн бүтцийн загварыг хавсралт 1-ээс харах/*
- 6.3 Хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр 7 хоног, сараар дэлгэрэнгүй, хураангуй тайлан гаргах;
- 6.4 Үүссэн гомдол маргааныг шийдвэрлэх зорилгоор тухайн радиогийн эфирийн бичлэгээс холбогдох нэвтрүүлгийн тодорхой цагийн бичлэг нийлүүлэх;



## 7. АЖЛЫН ДААЛГАВРЫН ШАЛГУУР, ШААРДЛАГА

### 7.1 Ерөнхий шаардлага

- Гүйцэтгэгч болон хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд хамрагдаж байгаа этгээд нь компанийн тухай хуулийн 6.14-т заасан /нэг/ нэгдлийн оролцогчид биш байна.
- Гүйцэтгэгч нь хорооноос олгодог өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч бус байх, гүйцэтгэх удирдлагын хувьд сүүлийн 3 жил аль нэг радиогийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх удирдлагаар ажиллаагүй байна.

### 7.2 Техникийн болон туршлага, хүний нөөцийн шалгуур

Энэхүү ажил нь радиогийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, мониторинг хийж, илэрсэн зөрчил дутагдлын дагуу шат дараатай арга хэмжээ авах үндэслэл шалтгаан болох бөгөөд шат дараатай арга хэмжээнд зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах, тусгай зөвшөөрлийг сунгах эсэх талаар дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ хамаарах тул хянуур нямбай ажиллаж, үнэн зөв алдаагүй тайлан гаргах, эфирийн дэлгэрэнгүй протокол, тайлан зөрүүгүй байх талаар анхаарч ажиллана. Энэхүү ажлын даалгаврыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гэрээлэгч нь дараах чадвар, мэдлэг, туршлагатай байх шаардлагатай.

Үүнд:

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа радиогийн үйлчилгээ эрхлэгчдээс тухайн сард графикийн дагуу сонгогдсон 10 радиогийн хөтөлбөрт нэгэн зэрэг, гэрээнд заасан хугацаанд байнгын хяналт, мониторинг хийх техникийн болон ажиллах хүчний боломжтой байна.
- Дээрх тооны радиогийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийх, эфирийн бичлэг хийх, хадгалах бүрэн хүчин чадал бүхий сервер, архивын системтэй байна.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа жагсаалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн сигналыг хүлээн авах техникийн шийдэл, нөөц шийдэл, хүчин чадал, байр талбайн нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.
- Цахилгааны доголдлоос хамааралгүйгээр хяналт, мониторингийн үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай хийх боломжтой байх, эфирийг тасралтгүй бичих, хэвийн ажиллагааг хангах нөөц станцтай байна.
- Ажлын даалгаварт өгөгдсөн мэдээ, тайлан, эфирийн бичлэг хадгалах мэдээллийн сантай байна.
- Мэдээллийн сангаас ажлын даалгаварт заасны дагуу, шаардлагатай тохиолдолд холбогдох бусад мэдээ, тайлан, эфирийн бичлэгийг тухайн сар, өдөр, цаг минутаар түргэн шуурхай гаргах техник, технологийн боломжтой байна.

- Хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд эфирийн бичлэгийг 3-аас доошгүй сар хадгалах сервер тоног төхөөрөмжтэй байна.
- Хяналт, мониторингийн үйлчилгээг хийх аргачлал, хяналт, мониторингийн ажлын үе шат, хяналт, мониторингийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, үе шат тус бүр дээр хийгдэх ажлын тодорхойлолт, ажилчдын тоо, ажил үүргийн хуваарь /ажлын байрны тодорхойлолт хавсаргах/ зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг хяналтын үзүүлэлт тус бүрээр гаргасан байна.
- Нөхцөл шаардлагад өөрчлөлт орж хяналт, мониторинг хийх үзүүлэлт өөрчлөгдөх тохиолдолд өөрчлөлтийг түргэн шуурхай хийх чадвартай байна.
- Урьдчилгаа төлбөр авалгүйгээр “Ажлын даалгавар”-т тусгасан ажлыг хэрэгжүүлэх санхүүгийн чадамжтай байна.
- Датабааз, файлын сан, програм хангамж, мэдээллийг цахим халдлагаас хамгаалах мэдээллийн аюулгүй байдлыг хангасан системийн шийдэлтэй байна.

Гүйцэтгэгч нь дараах хүснэгтэд тусгасан шаардлагатай мэдлэг чадвар, туршлагатай боловсон хүчнээс бүрдсэн баг санал болгох ба гэрээнд заасан ажил үүргийг заасан хугацаанд гүйцэтгэх чадвартай байна. Мөн дараах мэдлэг чадварыг зохих түвшинд хангаж, санал болгож буй ажлын төлөвлөгөө ба арга зүйд тулгуурлан хамгийн сайн баг бүрдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Албан тушаал	Чиг үүрэг	Тоо	Ажлын туршлага
Багийн ахлагч	Ажлыг удирдан зохион байгуулах, гэрээлэгчийг төлөөлж захиалагчтай харьцах	1	<ul style="list-style-type: none"> <li>• Хяналт, мониторингийн төсөлд ажилласан туршлагатай байх,</li> <li>• Судалгаа, шинжилгээ, статистик буюу холбогдох чиглэлээр зэрэг цолтой бол давуу тал болно,</li> </ul>
Мониторингийн менежер	Хяналт, мониторингийн тайлан мэдээний бүтэц, загварыг боловсруулах, хяналт тавих	1	<ul style="list-style-type: none"> <li>• Статистик, судалгаа шинжилгээний чиглэлээр дээд мэргэжилтэй</li> <li>• Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай,</li> <li>• Мэдээ, тайланг алдаагүй, нягт нямбай гаргах чадвартай</li> <li>• Энэ чиглэлээр ажилласан туршлагатай байх</li> </ul>
Програм хангамж хариуцсан ажилтан	Програм хангамж боловсруулах, шинэчлэлт, сайжруулалт хийх, Техникийн бүрэн бүтэн байдал, серверийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хариуцах	1	<ul style="list-style-type: none"> <li>• Програм хангамжийн чиглэлээр 2 жилээс багагүй ажилласан туршлагатай байх,</li> <li>• Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх,</li> <li>• Програм хангамж боловсруулах өөрчлөлт,</li> </ul>

			шинэчлэлтийг хийх чадвартай байх, <ul style="list-style-type: none"> <li>Техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах чадвартай байх</li> </ul>
Техник, ашиглалт хариуцсан ажилтан	Техникийн бүрэн бүтэн байдал, серверийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хариуцах	1	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлээрээ 2 жил ажилласан туршлагатай байх,</li> <li>Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх,</li> <li>Техник төхөөрөмжийн шинэчлэлт хийх, ашиглалт үйлчилгээг хийх, техникийн өргөтгөл хийх чадвартай байх,</li> <li>Техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах чадвартай байх</li> </ul>
Статистик судалгааны мэргэжилтэн	Хяналт, мониторингийн тайлан мэдээнд анализ хийх, хяналт, мониторингийн явцад хяналт тавих	1	<ul style="list-style-type: none"> <li>Дээд боловсролтой,</li> <li>Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай байх,</li> </ul>
Хяналт, мониторингийн ажилтан	Мэдээллийн дата үүсгэх, хяналт, мониторингийн тайлан бэлдэх	4	<ul style="list-style-type: none"> <li>Дээд боловсролтой,</li> <li>Их хэмжээний мэдээллийн баазтай ажиллах чадвартай,</li> </ul>

## 8. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ БА АЖЛЫН ХУВААРЬ

Гүйцэтгэгч нь энэхүү ажлын даалгаврын хүрээнд хөтөлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах арга зүй, үйл ажиллагааны хуваарийг боловсруулна. Энэхүү үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөө болон үүнтэй ижил төстэй даалгаврыг ямар хугацаа, техникийн туслалцаа, ажлын бүтэц бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байсан туршлагын баримтжуулалтыг хавсаргавал зохино.

## 9. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ УДИРДАМЖ

Хяналт, мониторингийн тайлан мэдээг долоо хоног, сараар гаргаж захиалагч талд электрон хэлбэрээр сар бүрийн тодорхой хугацаанд хүлээлгэн өгнө. Тайлан ирүүлэхдээ тайлангийн хугацаанд хамрагдсан радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо, үүнд шинээр нэмэгдсэн эсвэл хяналт, мониторингд хамрагдаагүй бол хамрагдаагүй шалтгаан зэргийг тайлбарласан товч тайлбар, тайлан, нотломжийг хамт ирүүлнэ. Тухайн радиогийн хөтөлбөр тасарсан тохиолдолд тухай бүр шалтгааныг тодруулж энэ талаар захиалагч талд мэдэгдэх шаардлагатай.

Гүйцэтгэгч нь тайлангийн бүтэц, аргачлалын дагуу тайланг нэгтгэж, дүгнэлт гаргахад ойлгомжтой, ирүүлсэн тайлан, мэдээг шууд ашиглах боломжтой, дахин боловсруулалт хийх шаардлагагүй, хялбар байдлаар ирүүлнэ. Ирүүлсэн тайлан мэдээнд алдаа гарсан нь тогтоогдсон, тайлан мэдээг заасан хугацаанд

ирүүлээгүй, урт хугацаагаар /14 хоногоос дээш/ хоцроосон тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дуусгавар болгох үндэслэл болно.

#### 9.1 Тайлан гаргах хугацааны хуваарь, хүргүүлэх хэлбэр

- Тухайн сарын хяналт, мониторингийн тайланг дараа сарын 10-ны дотор, электрон хэлбэрээр гаргаж захиалагчид нийлүүлнэ. Тайлан ирүүлэх хугацааг шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулахад нарийвчлан 2 тал тохиролцож болно.
- Тухайн сарын хяналт, мониторингийн тайлан өгөхдөө тухайн сарын товч тайланг (ажлын даалгаварт заасан хяналт, мониторингийн үзүүлэлтийн дагуу гаргасан тайлан радиогийн үйлчилгээ эрхлэгч тус бүрийн нэгдсэн дүн мэдээ тайлан, тайлангийн хугацаа зэргийг агуулсан байна), хяналт, мониторингд хамрагдсан хугацаа, хамрагдсан радиогийн жагсаалт, хяналт, мониторингд хамрагдаагүй газруудын жагсаалт (хамрагдаагүй шалтгаан, тайлбарын хамтаар) албан бичгээр ирүүлнэ.
- Мониторингийн тайланг нэгдсэн байдлаар улирал тус бүрээр дараагийн улирлын эхний сарын 30-ны өдрийн дотор, жилээр гаргах аналитик тайланг тайлан тус бүрт тусгасан үзүүлэлт бүрээр гаргаж дараа жилийн эхний улиралд багтаан ирүүлнэ.
- Гүйцэтгэгчийн хяналтын ажилтан өдөр бүрийн тайланг нэгтгэн дараа сарын эхэнд программын аргаар датабаазаас Excel хэлбэрээр тайлангуудыг гаргаж, Захиалагчид и-мэйлээр илгээнэ. Тайлан бүрийг дэлгэрэнгүй болон хураангуй 2 хэлбэрээр гаргах ба нийт тайланг CD –д бичиж баталгаажуулан захиалагчид нэхэмжлэхийн хамт биечлэн хүргүүлнэ.

--oOo--

## МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ /загвар/

- ✓ Эфирийн тухайн 7 хоногийн өдөр бүрийн (06:00-24:00) протокол; Эфирийн өдрийн протокол нь огноо, тухайн нэвтрүүлэг эсвэл зар сурталчилгаа эхэлсэн, дууссан хугацаа, үргэлжилсэн хугацаа, нэр, төрөл зэрэг бүх л мэдээллийг агуулсан байна.
- ✓ Арилжааны зар сурталчилгааны цацалтын хугацааг үндсэн эфирийн цаг тус бүрээр нь тусад нь гаргасан өдөр бүрийн тайлан, болон хураангуй тайлан; уг тайлан нь эфирийн аль цагт, ямар нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгааны хэтрэлт гарсан, зар сурталчилгааны төрөл, ангилал, тайлбар, хэтрэлтийн нэгдсэн дүнг агуулсан байна. Зар сурталчилгааны хэтрэлтийг тайлан хүснэгтийн дор өдөр бүр, 7 хоног, сараар нэгтгэж нийт цагийг гаргана.
- ✓ Үндэсний бүтээл, нэвтрүүлгийн хувь, өөрийн бүтээлийн хувь, гадаад, Монгол дууны хувь, мэдээ мэдээллийн нэвтрүүлгийн хувь хэмжээг гаргасан тайланд огноо, нэвтрүүлэг эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, гадаад, Монгол дуу, мэдээ болох тайлбар, 7 хоногийн эцэст хөтөлбөрийн нийт цагийг цаг:мин:сек-ээр гаргах, үндэсний бүтээл, нэвтрүүлэг, өөрийн бүтээл, Монгол дуу, мэдээний нийт цаг, эзлэх хувь
- ✓ Хөтөлбөрт эзлэх үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт хугацаа, эзлэх хувийг сар бүрээр гаргасан тайлан; уг тайлан нь огноо, тухайн нэвтрүүлэг эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, нэр, төрөл, нийт нэвтрүүлгийн үргэлжилсэн хугацаа зэргийг тухайн сард чиглэл тус бүрээр ирүүлнэ.  
Эдгээр тайланг долоо хоног, сараар нэгтгэсэн тайланг хураангуй байдлаар гаргана. Мөн дээрх 4 ангиллаар тус бүрт нь гаргасан тайланг дэлгэрэнгүй, хураангуй байдлаар гаргана.
- ✓ Насанд хүрэгчдэд зориулсан 18 наснаас дээш насныханд зориулсан нэвтрүүлгийг 06:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлсэн, давтан дамжуулсан зөрчил гаргасан радиогийн зөрчлийн тайланг өдөр бүр, 7 хоног, сараар нэгтгэж гаргах, дамжуулсан огноо, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, тайлбарын хамт
- ✓ Хөтөлбөрт эзлэх хөтлөлттэй шууд нэвтрүүлгийн хувь хэмжээг гаргасан тайланд нэвтрүүлэг эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, 7 хоног, сараар эцэст хөтөлбөрийн нийт цагийг цаг:мин:сек-ээр гаргах, нэвтрүүлгийн нийт цаг, эзлэх хувийг агуулсан байна.

РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ЖАГСААЛТ, ХӨТӨЛБӨРТ  
ХЯНАЛТ МОНИТОРИНГ ХИЙХ ХУВААРЬ  
/сар бүр 10 радио түүврээр/

№	ДАВТА МЖ, МГЦ	ЭЗЭМШИГЧ	РАДИОГИЙН НЭР	ХАМРАХ ХҮРЭЭ
1	88.3	Эм Жи Эл Радио ньус ХХК	Эм Жи Эл Радио Ньус	Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Өмнөговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Булган, Баянхонгор, Архангай, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Увс аймаг
2	88.8	СКОД ХХК	Medee.mn	Улаанбаатар хот
3	89.3	Сета тех ХХК	Аялгуу	Улаанбаатар хот
4	89.7	Жавзандамба хутагт төв ТББ	Зохист аялгуу	Улаанбаатар хот
5	90.5	Улаанбаатар телевиз ХХК	VIP радио	Улаанбаатар хот
6	91.1	Монгол комикс ХХК	Цаг үе залуус	Улаанбаатар хот
7	91.7	Хэмнэлт долгион медиа групп ХХК	Метро лоунж	Улаанбаатар хот
8	92.1	Смарт коммуникэйшн ХХК	Тойм	Улаанбаатар хот
9	92.5	Тэргүүн медиа ХХК	Стар	Улаанбаатар хот
10	95.1	Шүхэр ТББ	Хамаг Монгол	Улаанбаатар хот
11	95.7	Хүүхэд, ирээдүй, соёл боловсрол сан ТББ	Арга билиг	Улаанбаатар хот
12	96.3	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	Авто радио	Улаанбаатар хот
13	96.9	Эх элгэн нутаг ХХК	Элгэн нутаг	Улаанбаатар хот
14	97.5	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд шашинтны төв	Лавайн эгшиг	Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Өмнөговь, Даланзадгад, Дундговь, Орхон, Өвөрхангай, Булган,

				Баянхонгор, Архангай, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Увс аймаг
15	98.1	Радиоком Монгол ХХК	Формула	Улаанбаатар хот
16	98.5	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ	Best	Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Ховд, Увс аймаг
17	98.9	Монголиан Мюзик Медиа ХХК	Бизнес радио	Улаанбаатар хот
18	99.3	Ньюмедиа ХХК	Инээмсэглэл	Улаанбаатар хот
19	99.7	Дижитал радио ХХК	Их Монгол	Улаанбаатар хот
20	100.1	РФ ХХК	kiss radio	Улаанбаатар хот
21	100.5	НС Холбоо ХХК	Гийнгоо	Улаанбаатар хот
22	101.7	Агрегатор ХХК	Тэргүүлэгч	Улаанбаатар хот
23	102.1	Эм Эс Жи Эм Эл ХХК	Монголчуудын радио	Улаанбаатар хот
24	102.5	Бадруун ХХК	Радио УБ	Улаанбаатар хот
25	103.6	Медиахолдинг ХХК	Тэнгэрлэг радио	Улаанбаатар хот
26	104	Ви Өү Эм ХХК	Эрүүл амьдралын радио	Улаанбаатар хот
27	104.5	Салхи Энтертэйнмэнт ХХК	Гэр бүлийн радио	Улаанбаатар хот, Улаанбаатар.Багануур дүүрэг, Улаанбаатар.Налайх дүүрэг, Дорнод.Хэрлэн сум, Сүхбаатар.Баруун-Урт сум, Хэнтий.Хэрлэн сум, Төв.Зуунмод сум, Говьсүмбэр.СҮМБЭР, Сэлэнгэ.Сүхбаатар сум, Дорноговь.Сайншанд сум, Дархан-Уул.Шарын гол сум, Дархан-Уул.Хонгор сум, Дархан-Уул.Орхон сум, Дархан-Уул.Дархан сум, Өмнөговь.Даланзадгад сум, Дундговь.Сайнцагаан сум, Орхон.Жаргалант сум, Орхон.Баян-Өндөр сум,

				Өвөрхангай.Арвайхээр сум, Булган.Булган сум, Баянхонгор.Баянхонгор сум, Архангай.Эрдэнэбулган сум, Хөвсгөл.Мөрөн сум, Завхан.Улиастай сум, Говь-Алтай.Есөнбулаг сум, Баян-Өлгий.Өлгий сум, Ховд.Жаргалант сум, Увс.Улаангом сум
28	104.7	Буян налайх ХХК	Буян	Улаанбаатар
29	105.5	Чугу ХХК	VIBE	Монгол Улс
30	106.6	Стандарт Ви Оү Эй ХХК	Америкийн дуу хоолой	Улаанбаатар хот
31	107	И Зэт Эф Эм ХХК	Эх дэлхий радио	Улаанбаатар хот
32	107.5	Билэг санаа ХХК	Шинэ долгион	Улаанбаатар хот
33	100.9	МҮОНРТ	РЗ залуусын радио /МҮОНР-III суваг/	Улаанбаатар хот
34	103.1	МҮОНРТ	Монголын радио /МҮОНР-II суваг/	Монгол Улс
35	106	МҮОНРТ	Монголын радио /МҮОНР 1-р суваг/	Монгол Улс

Жич: Дээрх тусгай зөвшөөрөлтэй радиогоос хөтөлбөрийн хяналт, мониторингд сар бүр түүврээр хамрагдах 10 радиог түүвэрлэн авч,хуваарь гарган Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд нарийвчлан тусгана.

Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн нөхцөл шаардлагын хэрэгжилтийн байдал, өмнөх саруудын хяналт, мониторингийн дүн, үйл ажиллагаа явуулж байгаа эсэхээс хамааран хуваарьт орох радиогийн нэрс өөрчлөгдөх боломжтой тул хяналт, мониторингийн сар эхлэхээс өмнө Захиалагч талтай гэрээнд хавсаргасан хуваарьт заасан 10 радиогийн жагсаалтыг дахин хянаж, харилцан тохирсон байна.